


ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Монгол улсын Ерөнхий аудиторт 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн, аймгийн ИТХ-аас ирүүлсэн захиалгын дагуу хийгдсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

“Амь-Ус Трейд” ОНӨААТҮГ -ын үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын ажлуудын үр дүн



2017 оноос орон тоо нь нэмэгдсэнээр удирдлагын зардал өсч, үйл ажиллагааны үр дүн буурч, алдагдалтай ажиллаж эхэлжээ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Монгол улсын Ерөнхий аудиторт 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн, аймгийн ИТХ-аас ирүүлсэн захиалгын дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймаг дахь Төрийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт

“Амь-Ус Трейд” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын ажлуудын үр дүн сэдэвт аудитыг хийхдээ дараахь зорилтыг дэвшүүллээ.

- ОНӨААТҮГ нь орлого, зардлаа үндэслэлтэй төлөвлөж, үр ашигтай ажиллаж байна уу?
- ОНӨААТҮГ нь бүтэц, орон тоогоо оновчтой зохион байгуулан дэвшүүлсэн зорилго, зорилтоо хэр зэрэг биелүүлсэн бэ?
- Хөрөнгийн худалдан авалт, ашиглалт, зарцуулалт, арвилан хэмнэлт, үр нөлөөтэй байна уу?
- Хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрөөр хийгдсэн ажил үр дүнтэй байна уу?

Хамарсан хүрээ

“Амь-Ус Трейд” ОНӨААТҮГ-ын 2016 он, 2017 оны эхний улирлын үйл ажиллагааны үр дүнг шалгалаа.

Арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглах, холбогдох албан тушаалтан нартай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, санхүүгийн болон ажлын тайлан, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийж аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн шалгалтын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг аймаг дахь Төрийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Л.Уламбаяр, аудитын менежер Б.Дагвасүрэн нар хянан удирдаж, аудитор Г.Заяа багийг ахлан, шинжээч Г.Чулуунбаатартай хамтран 2017 оны 04 дүгээр сарын 25-наас 2017 оны 06 дугаар сарын 01-ний хооронд гүйцэтгэлээ.

Ерөнхий мэдээлэл:

“Амь-Ус Трейд” ОНӨААТҮГ нь 2016 онд 218 аж ахуйн нэгж байгууллага, 935 айл өрхөд 217,483 куб/метр цэвэр усыг төвлөрсөн шугам сүлжээгээр, гэр хорооллын айл өрхүүдэд 19,183 куб/метр цэвэр усыг зөөвөрлөн түгээж 609.0 сая төгрөгийн борлуулалтын орлогыг төвлөрүүлжээ. Өмнөх онтой харьцуулахад хэрэглэгчдийн тоо нэмэгдсэн боловч борлуулалтын орлого 1.8 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд 50 ажиллагсадтай, 581.7 сая төгрөгийн зардалтайгаар, 24.3 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. 2017 онд 622.2 сая төгрөгийн борлуулалтын орлого төвлөрүүлж, 617.0 сая төгрөгийн зардалтай ажиллахаар төлөвлөжээ.

Бүлэг 1. Айл өрхийн болон аж ахуйн нэгж байгууллагын борлуулалтын орлогыг үндэслэлтэй төлөвлөөгүй, 2017 онд өмнөх оноос орлого дутуу төвлөрч, зардал нэмэгдсэн байна.

1.1. Айл өрхийн болон аж ахуйн нэгж байгууллагын борлуулалтын орлогыг дутуу төлөвлөсөн, 2017 оны эхний улирлын орлогын төвлөрүүлэлт өмнөх жилээс буурсан байна.

Тус байгууллага нь өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн 2016 онд 602.7 сая төгрөгийн, 2017 онд 622.2 сая төгрөгийн борлуулалтын орлого төлөвлөн Төлөөлөн удирлах зөвлөлөөрөө батлуулсан байна. 2016 онд борлуулалтын орлогыг төлөвлөхдөө өмнөх оны гүйцэтгэлээс 2.1 хувиар өсгөж төлөвлөсөн бол 2017 онд сууц өмчлөгчдийн холбоо шинээр байгуулагдсантай холбоотойгоор борлуулалтын орлого буурч төлөвлөгдсөн байна.

Борлуулалтын орлогын төлөвлөлтийг өмнөх онуудын гүйцэтгэлтэй тулган шалгахад зөөврийн усны орлогыг үндэслэлтэй төлөвлөсөн, өмнөх оны гүйцэтгэлээс айл өрхийн болон аж ахуйн нэгж байгууллагын борлуулалтын орлогыг дутуу төлөвлөсөн байна. Тухайлбал:

- Аж ахуйн нэгж байгууллагын борлуулалтын орлогыг төлөвлөхдөө 2016 онд 30 байгууллагын орлогыг 69.7 сая төгрөгөөр дутуу, 50 байгууллагын орлогыг 70.1 сая төгрөгөөр илүү төлөвлөсөн. 2017 онд өмнөх оны гүйцэтгэлээс 50 байгууллагын орлогыг 82.3 сая төгрөгөөр дутуу, 49 байгууллагын орлогыг 63.1 сая төгрөгөөр илүү төлөвлөсөн байна. Энэ нь орлогын байцаагч нар төлөвлөгөөг гаргахдаа аж ахуйн нэгж байгууллагын орлогын гүйцэтгэлийг судалж, хэрэглээний өөрчлөлтөнд харьцуулалт хийдэггүйтэй холбоотой байна.
- Айл өрхийн борлуулалтын орлогын төлөвлөлт байцаагч нарын бичилтээс 2016 онд 12.2 сая төгрөгөөр, 2017 онд 13.3 сая төгрөгөөр тус тус дутуу төлөвлөгдсөн байна. Энэ нь шинээр нэмэгдсэн хэрэглэгчдийг төлөвлөгөөнд тусгаагүйтэй холбоотой байна.

/ сая.төгрөгөөр /

д/д	Үзүүлэлт	2015 оны гүйцэтгэл	2016 оны төлөвлөгөө	2016 оны төлөвлөгөө Аудитаар	2016 оны гүйцэтгэл	2017 оны төлөвлөгөө	2017 оны төлөвлөгөө Аудитаар
1	Усан хангамж	537.5	549.9	561.7	535.5	539.2	570.8
	ААНБ	440.4	451.4	451.0	440.6	442.3	461.5
	Айл өрх	82.1	83.1	95.3	94.9	96.9	109.3
	СӨХ	15.0	15.4	15.4			
	Зөөврийн усан хангамж	46.7	46.8	46.8	47.6	47.8	47.8
	үнээс	зөөврийн ус, усан сан, худаг	42.6	42.7	42.7	44.3	44.5
		1-р халуун ус	2.4	2.4	2.4	2.4	2.4
		2-р халуун ус	1.7	1.7	1.7	0.9	0.9
3	Бусад	5.6	6.0	6.0		35.2	21.4
	Бусад орлого	5.6	6.0	5.2	4.9	4.0	2.0
	Бусад хөрөнгө оруулалт				21.0	31.2	19.4
	Нийт дүн	589.8	602.7	613.7	609.0	622.2	640.0

2016 оны борлуулалтын орлого хангалттай хэмжээгээр төвлөрсөн бол 2017 оны борлуулалтын орлогын төвлөрсөн байдал өмнөх оноос буурсан байна.

2016 онд зөөврийн усны орлого бүрэн төвлөрч, айл өрхийн орлогын 97.3 хувь нь, аж ахуйн нэгж байгууллагын орлогын 97.6 хувь нь, бусад орлогын 81.7 хувь нь төвлөрч, нийт орлогын 97.6 хувь нь төвлөрсөн байна. Бусад орлогын төлөвлөгөө тасарсан нь КАТ машинаас олох орлогыг өндөр төлөвлөснөөс шалтгаалжээ.

Айл өрхийн орлого бодит байдлаас дутуу төлөвлөгдсөн байсан тул аудитын явцад орлогын байцаагч нарын бичилтийн орлогыг, авлагын бүртгэлтэй тулган шалгасан.

Тайлант онд төлөвлөгөөнд тусгагдалгүйгээр Улиастай сумын ОНХС, аймгийн байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 21.0 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна.

2017 оны эхний улиралд 114.2 сая төгрөгийн борлуулалтын орлого, 17.6 сая сая төгрөгийн нэмэлт орлого бүрдүүлсэн нь төлөвлөгөөнөөс 23.8 сая төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 31.6 сая төгрөгөөр дутуу байна. Цаашид төлөвлөсөн орлогыг бүрэн төвлөрүүлэх талаар анхаарч ажиллах шаардлагатай байна.

1.2. 2017 оны эхний улиралд алдагдалтай ажиллан, цалин, шатахууны зардлуудыг үр ашиггүй, арвилан хэмнэлтгүй зарцуулж байна.

“Амь-Ус Трейд” ОНӨААТҮГ-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2016 оны 1 дүгээр сард 51 орон тоотойгоор, 587.9 сая төгрөгийн зардалтай ажиллахаар төсвийг баталсан бөгөөд тайлант онд 581.7 сая төгрөгийн зардал гарган төсвийг 8.7 сая төгрөгөөр хэмнэсэн байна. Зардлын гүйцэтгэлийг нэр төрлөөр нь өмнөх онтой харьцуулбал дараахь байдалтай байна.

Үзүүлэлт	2015 оны гүйцэтгэл	2016 оны төсөв	2016 оны гүйцэтгэл	2017 оны төсөв	2017 оны гүйцэтгэл
Цалин	276.7	276.6	276.6	303.0	77.6
НДШ	33	33.2	34.3	36.3	9.4
Цахилгааны зардал	47.9	48.5	51.0	50.2	13.6
Шатахууны зардал	39.5	40.8	38.0	37.0	9.7
Түлээ, нүүрс	4.1	4.5	3.8	3.6	
Материалын зардал	30.0	32.0	27.2	15.0	2.7
Сэлбэг хэрэгсэл	9.0	8.0	8.8	8.0	0.1
Хөдөлмөр хамгаалал	4.1	3.5	4.7	4.1	0.2
Элэгдэл	37.6	41.5	31.3	34.8	15.2
Албан томилолт	4.8	3.0	4.3	4.1	0.6
Бичиг хэрэг, холбоо	5.4	4.8	5.5	4.9	1.4
Тээврийн зардал	2.2	2.0	3.0	2.5	0.7
Зар сурталчилгаа	1.3	0.5	0.4	0.5	
Шагнал урамшуулал	0.3	2.0	0.5	2.0	
Тэтгэмж		0.2	9.2	3.8	1.3
Сургалт семинар	0.4	4.0	0.2	2.0	0.2
Найдваргүй авлагын зардал		2.5		2.5	
Татвар, төлбөр, даатгал	3.7	3.9	3.7	4.3	
Нийгмийн арга хэмжээний зардал	20.0	20.3	25.4	20.5	3.0
Засвар үйлчилгээ	16.6	10.0	8.8	0.7	
ТУЗ зардал	6.9	6.2	5.6	6.2	1.9
Бохирын ажлын хөлс		2.0	1.1	2.0	
Усны шинжилгээ	1.6	1.5	2.7	1.5	
Халаалт	20.7	24.3	24.7	24.9	4.8
Бусад зардал		7.0	8.4	2.6	1.1
Лабораторийн зардал	0.5	3.0		15.0	
Усны зохицуулах зөвлөл		2.1		2.6	
Тулгуур багануудад хагалбар хийх				19.4	
Урсгал засвар				3.0	
Нийт дүн	566.3	587.9	579.2	617.0	143.5

Дээрх хүснэгтээс харахад 2016 онд батлагдсан төсвөөс албан томилолт 1.3 сая төгрөгөөр, тэтгэмж 9.0 сая төгрөгөөр, бусад зардал 1.4 сая төгрөгөөр, нийгмийн арга хэмжээний зардал 5.1 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн бол найдваргүй авлагын зардал 2.5 сая төгрөгөөр, лабораторийн зардал 3.0 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Зардал хэтэрсэн шалтгааныг судалж үзвэл дараахь байдалтай байна.

- ✓ 2016 онд нийтээр тэмдэглэдэг баяр ёслолын 4 удаагийн арга хэмжээний зардлыг байгууллагын төсвөөс санхүүжүүлснээс шалтгаалан нийгмийн арга хэмжээний зардал хэтэрсэн
- ✓ Өмнөх захирал нь Улаанбаатар хот руу 3 удаа албан томилолтоор ажиллахдаа онгоцоор зорчин үрэлгэн зардал гаргаснаас шалтгаалан албан томилолтын зардал хэтэрсэн
- ✓ Тэтгэмжийн зардлын хэтрэлт нь төлөвлөлт бодитой бус байснаас шалтгаалжээ.

Тайлант хугацаанд төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор батлагдсан бүтэц орон тоо болон цалингийн сангийн төлөвлөлтийн өөрчлөлтийг харьцуулбал дараахь байдалтай байна.


Бүтэц	2016 оны төсөвлөгдсөн цалин		2016 оны 10 дугаар сард өөрчлөгдөж төлөвлөгдсөн цалин		2017 онд төсөвлөгдсөн цалин	
	Орон тоо	Цалингийн сан	Орон тоо	Цалингийн сан	Орон тоо	Цалингийн сан
Захиргаа аж ахуй	3	37.3	4	40.0	12	99.3
Ус сувгийн хэсэг	30	183.0	28	179.0	17	111.9
Зөөврийн ус	18	56.4	18	56.4	23	91.8
Дүн	51	276.6	50	275.4	52	302.9

2016 онд гүйцэтгэлээр 47-48 орон тоотойгоор ажиллаж байсан бол 2017 онд 2 слесарийн орон тоог цомхотгон, захиргаа аж ахуйн ажилтнуудын тоог 6 ажилтнаар нэмэгдүүлж, цалингийн сангийн төлөвлөлт өмнөх оноос 26.3 сая төгрөгөөр өссөнөөс шалтгаалан 2017 оны төсөв 617.0 сая төгрөгийн зардалтайгаар батлагдан өмнөх оны гүйцэтгэлээс 29.1 сая төгрөгөөр өсчээ.

Дээрхи байдлаас дүгнэхэд үйлдвэрийн газрын ТУЗ нь орлого нэмэгдүүлэх боломжийг судалж үзэлгүйгээр, зардлыг нэмэгдүүлэн баталж байгаа нь цаашид алдагдалтай ажиллах нөхцлийг бүрдүүлж байна.

2017 оны 1 дүгээр улиралд 143.5 сая төгрөгийн зардалтайгаар, 11.7 сая төгрөгийн алдагдалтай ажиллажээ.

Аудитын явцад нийт зардалд эзлэх удирдлагын зардлын өсөлт, бууралтыг харьцуулж үзэхэд 2017 оноос удирдлагын зардлын эзлэх хувь өмнөх оноос 2 дахин өссөн байгаа нь ажиглагдсан тул ОНӨААТҮГ-ын ТУЗ-д гүйцэтгэх захирлын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, гэрээг дүгнэж ажиллах зөвлөмжийг хүргүүллээ.



2017 оны 1-р улиралд батлагдсан төсвөөс цалингийн сан 1.9 сая төгрөгөөр, гэрэл цахилгааны зардал 1.0 сая төгрөгөөр, тэтгэмж 0.4 сая төгрөгөөр, бусад зардал 0.5 сая төгрөгөөр, элэгдлийн зардал 6.5 сая төгрөгөөр, шатахуун 0.5 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн байна.

Зардал хэтэрсэн шалтгааныг судалж үзвэл дараахь байдалтай байна.

- ✓ Батлагдсан төсвөөс хоолны нэмэгдлийг 1.0 сая төгрөгөөр, орлогын байцаагчийн цалинг 0.08 сая төгрөгөөр, цалингийн нэмэгдлийг 0.8 сая төгрөгөөр тус тус илүү олгосноос шалтгаалан цалингийн сан хэтэрсэн
- ✓ Цахилгааны зардлын хэтрэлт нь хүйтний улиралд 1, 2 дугаар өргөлтийн станцуудыг халаах зорилгоор тенг ашигладгаас шалтгаалсан
- ✓ Сард зарцуулах шатахууны лимитийг тогтоогоогүйгээс шалтгаалан шатахууны зардал хэтэрсэн
- ✓ Бүтэц зохион байгуулалт өөрчлөгдөн 3 ажилтан ажлаас халагдсантай холбоотойгоор тэтгэмжийн зардал хэтэрсэн
- ✓ 2016 онд 25.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж бэлтгэсэнтэй холбоотойгоор элэгдлийн зардал хэтэрсэн байна.

Аудитын явцад шуудан холбоо, шатахууны зардлын зарцуулалтыг батлагдсан лимиттэй, зардлуудын гүйцэтгэлийг анхан шатны баримттай нь тулган шалгахад арвилан хэмнэлт, үр ашигтай байдлыг хангаагүй дараахь зөрчлүүдийг илрүүллээ.

1. Цагаан сар, олон улсын эмэгтэйчүүдийн баяр, төрийн тахилга, баруун бүсийн 5 аймгийн бүсчилсэн тэмцээн, нийтийн ахуй үйлчилгээний ажилтнуудын ойн баярын арга хэмжээний зардлыг байгууллагын төсвөөс санхүүжүүлсэн нь УИХ-ын 2016 оны 47 дугаар тогтоолыг зөрчсөн.
2. Аймгийн нэгдсэн эмнэлэгт 0.4 сая төгрөгийн хандив олгосон нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10-д “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно” гэж заасныг зөрчсөн.

3. Шатахууны зарцуулалтын тооцоог спидометрийн заалтыг үндэслэн хийдэггүй, жолоочийн тооцооны хуудсыг бүрэн бичдэггүй, 2016 оны 1-9 саруудад ОНӨААТҮГ-ын ТУЗ-өөс баталсан лимитийг мөрдөөгүй зэргээс шалтгаалан 3.2 сая төгрөгийн шатахууныг үрэлгэн зарцуулж, 1,1 сая төгрөгийн шатахууныг сонгуульд оролцохоор ажлаас чөлөөлөгдсөн үедээ зарцуулж байгууллагад хохирол учруулсан тул төлбөр болголоо. 2016 оны 09 дүгээр сард ОНӨААТҮГ-ын ТУЗ-өөс шатахууны зардлын лимитийг хүчингүй болгосноос шалтгаалан 2017 онд 1.2 сая төгрөгийн шатахууныг үрэлгэн зарцуулсан, гүйцэтгэх захирал нь холбооны зардлын сарын лимитийг өмнөх оноос 0.12 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн, зарим шаардлагагүй ажилтныг хамруулсан нь УИХ-ын 2016 оны 47 дугаар тогтоолыг зөрчиж байна. Цаашид шатахууны зардалд лимит тогтоон, хобооны зардлын лимитийг шинэчлэн, эдгээр зардлын зарцуулалтанд тавих хяналтыг сайжруулснаар 6.0 сая төгрөгийн зардлыг хэмнэх боломж байна.
4. Тайлант хугацаанд 8.9 сая төгрөгийн сэлбэг хэрэгслийг зарцуулахдаа техникийн комиссын акт үйлдэж, солих шаардлагатай болсныг нотлоогүй
5. 2016 оны 10 дугаар сард аймгийн ИТХ-ын шийдвэргүйгээр 14.0 сая төгрөгийн өртөгтэй Ланд 80 машин худалдан аваад, 2016 оны 11 дүгээр сард 1.6 сая төгрөгийн сэлбэг авч сайжруулалт хийн, шийдвэргүйгээр “Очир илч” ОНӨААТҮГ-т үнэ төлбөргүйгээр шилжүүлснийг үр ашиггүй зарцуулалт гаргасан гэж дүгнэж байна. Уг тээврийн хэрэгслийг шилжүүлэх шийдвэрийг аймгийн ИТХ-аас 2017 оны 1 дүгээр сард гаргасан тул машинд сайжруулалт хийсэн 1.6 сая төгрөгийг “Очир илч” ОНӨААТҮГ-аас буцаан төвлөрүүлэхээр акт тогтоолоо.
6. 2016 оны 11 дүгээр сараас хойш иргэн Г.Жаргалсайханы өмчлөлийн Iexus 470 автомашиныг гэрээ байгуулалгүйгээр захирлын хэрэгцээнд ашиглаж байгаа бөгөөд 1.6 сая төгрөгийн сэлбэг тавин сайжруулжээ. Тус байгууллага нь тээврийн хэрэгсэл худалдан авахаар 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 30.0 сая төгрөг тусгасан байгаа бөгөөд одоогоор аймгийн ИТХ-аас худалдан авах шийдвэрийг гаргаагүй, хөрөнгийн эх үүсвэр бүрдээгүй байна. Цаашид авто тээврийн хэрэгслийг худалдан авахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах нь зүйтэй байна.
7. 2016 оны 9 дүгээр сараас хойш удирдлагын цай, чихрийн зардалд сард дунджаар 0.15 сая төгрөг зарцуулж байгааг арвилан хэмнэлтгүй байна гэж үзэн 0.4 сая төгрөгийн зардлыг төлбөр болголоо.
8. 2016 онд 24.3 сая төгрөгийн ашигтай ажилласан мөртлөө орон нутгийн төсөвт түрээсийн орлого төвлөрүүлээгүй, байгууллагын дотоод үйл ажиллагаа, урамшуулалд хуваарилсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-д “Төрийн өмчийн түрээсийн төлбөрийг улсын төсөвт оруулна. Уг төлбөр тухайн эд хөрөнгийг худалдан авах үнийн төлбөрт үл хамаарна” гэж заасныг зөрчсөн байна.

Дээрх байдлаас дүгнэхэд орон тоо цалингийн сан нэмэгдсэн, шатахууныг хяналтгүйгээр үрэлгэн зарцуулдаг, авто тээврийн хэрэгслийн худалдан авалтыг үр ашиггүй хийж байгаа зэргээс дүгнэхэд цаашид ОНӨААТҮГ нь алдагдалтай ажиллах нөхцлийг бүрдүүлсэн байна.

Аудитын явцад усны алдагдлыг судалж үзэхэд дунджаар 22 хувьтай байгаа бөгөөд жилд 152.5 сая төгрөгийн алдагдал хүлээж байна.

Үзүүлэлт	2015 он	2016 он	2017 оны эхний улирал
Олборлосон нийт хэмжээ, куб/м	391,100	236,666	78,470
Усны алдагдал, куб/м	86,042	51,830	17,263

“Амь-Ус Трейд” ОНӨААТҮГ-ийн олборлосон усны хэмжээ 2016 онд өмнөх оноос 154,500 куб/метрээр буурсан нь шугам сүлжээний алдагдлыг бууруулж ажилласантай холбоотой ч 2016 оны 11 дүгээр сард 2 дугаар өргөлтийн станцын ерөнхий тоолуур эвдэрснээс шалтгаалсан гэж үзлээ. Энэ тоолуур эвдэрснээр нийт олборлож байгаа усны хэмжээ, алдагдлыг хянахад хүндрэл учирч байгаа тул яаралтай засварлах нь зүйтэй байна.

Усны алдагдлын гол шалтгаан нь орон сууцны айл өрхийн 78 хувь нь, аж ахуйн нэгж байгууллагын 41 хувь нь тоолуургүй байдагтай холбоотой байна.

Аудитын явцад “Амь-Ус Трейд” ОНӨААТҮГ нь доорх байдлаар 26.5 сая төгрөгийн орлого алдаж байгааг илрүүлэн, эдгээр газруудтай хийх гэрээгээ шинэчлэн тоолууржуулж, усны алдагдлын шалтгааныг арилгах талаар байгууллагын удирдлагуудтай хамтарч ажиллах зөвлөмжийг хүргүүллээ.

- ✓ 1 дүгээр 10 жилийн сургууль нь 2016 онд усны алдагдал их гаргаснаас 24.0 сая төгрөгийн усны төлбөр төлсөн бөгөөд усны алдагдлыг бууруулаагүй байж 2017 онд задгай тарифаар гэрээгээ байгуулснаас 12.0 сая төгрөгийн,
- ✓ Улиастай зочид буудлын цэвэр усны шугам дээр тоолуур байрлуулаагүйгээс 6.0 сая төгрөгийн,
- ✓ Дэвшил сургууль болон Улиастай ирээдүй хоршооны цэвэр усны шугамын алдагдлаас 7.7 сая төгрөгийн,
- ✓ Ардчилсан намын байртай цэвэр усны гэрээ байгуулаагүйгээс 0.8 сая төгрөгийн,

Нөгөө талаар тоолуургүйгээс айл өрхийн усны хэрэглээ нь бүрэн бичигддэггүй, эзэнгүй байсан хугацаанд ус хэрэглэсэн эсэхийг тогтоох боломжгүй, маргаан гардаг зэргээс харахад цаашид айл өрх, албан байгууллагыг тоолууржуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах нь зүйтэй байна.

Цаашид усны алдагдал, удирдлагын үр ашиггүй зардлыг бууруулснаар ашигтай ажиллах боломжтой байна гэж дүгнэж байна.

1.3. Авлагыг бууруулах ажил зохион байгуулсан ч үлдэгдэл нь өссөн байна.

2016 оны эхэнд 51.9 сая төгрөгийн авлагатай байсныг тайлант онд 24.7 сая төгрөгөөр бууруулсан боловч 2017 оны 3 дугаар сарын 31-ний байдлаар дахин авлага өсч 54.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй болсон байна. Эндээс харахад авлагын үлдэгдлийг бууруулах талаар үр дүнтэй ажил зохион байгуулаагүй байна гэж үзлээ.

Авлагын үлдэгдлийн 13.3 хувийг найдваргүй авлага эзэлж байгаа тул шүүх хяналтын байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлэх нь зүйтэй.

Эд хариуцагчийн бараа материалын тайланг авлага өглөгийн журналтай тулган шалгахад 2016 онд зөрчил илрээгүй, 2017 онд 0.8 сая төгрөгийн орлогыг авлагаар бүртгээгүй зөрчил илэрлээ.

Бүлэг 2. 2016 онд дэвшүүлсэн зорилго, зорилтоо хангалттай хэмжээнд биелүүлсэн ч бүтэц, орон тоог оновчтой зохион байгуулаагүй байна.

2.1. Бүтэц орон тоогоо оновчтой зохион байгуулаагүй, орон тоо нэмэгдсэн, ажлын ачаалал харилцан адилгүй, мэргэжлийн бус ажилтнуудын тоо өндөр байгаад анхаарч ажиллах шаардлагатай байна.

“Амь Ус” трейд ОНӨААТҮГ-ын орон тооны сүүлийн 3 жилийн судалгааг хүснэгтээр харуулбал:

Орон тооны судалгаа								
Алба, хэсэг	2015		2016.01		2016.10		2017	
	Амь Ус	Аудит аар	Амь Ус	Аудит аар	Амь Ус	Аудит аар	Амь Ус	Аудит аар
Захиргаа аж ахуй	3	7	3	7	4	7	12	9
Ус сувгийн хэсэг	29	25	30	26	28	25	17	24
Зөөврийн ус	18	18	18	18	18	18	23	19
Бүгд	50	50	51	51	50	50	52	52

2016 онд хүний нөөцийн ажилтан-нарийн бичиг, жолооч-касс аж ахуйн бэлтгэгч, үйлчлэгч, эдийн засагч-тооцооны нягтлан бодогч нарыг ус сувгийн хэсэгт, 2017 онд орлогын байцаагчийг захиргаа аж ахуйд, ерөнхий инженер, лабораторийн ажилтныг зөөврийн ус хэсэгт хуваарилан бүтцээ баталж байгаа нь шаардлага хангаагүй байна. Тус байгууллагын бүтцийг аймгийн Орон нутгийн өмчийн албанаас батлаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5-д “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захиргааны албан тушаалын жагсаалт, орон тооны нормативыг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тогтооно” гэж заасныг зөрчиж байна.

2017 онд захиргаа аж ахуйн хэсэг 12 орон тоотой, ус сувгийн хэсэг 17 орон тоотой, зөөврийн усны хэсэг 23 орон тоотой, нийт 52 орон тоотой ажиллахаас одоогоор лабораторийн 1 ажилтан, 1 резерварын харуулыг аваагүй, нийт 50 орон тоотойгоор ажиллаж байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.2 /ажлын байрны тодорхойлолтод заасан ажил, үүрэг/ дахь заалтыг үндэслэн ажиллагсдын ажлын байрны тодорхойлолтыг боловсруулахдаа Төрийн албаны зөвлөлийн 2004.11.08-ны өдрийн 34 дүгээр тогтоолоор баталсан “Ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолт”-ын дагуу бүх ажилчдыг хамруулан 2017 онд шинэчилж гаргасан байна.

Аудитын явцад байгууллагын ажилчдын ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарьтай танилцахад нягтлан бодогчийн ажлын ачаалал их, ахлах орлогын байцаагчийн, 2 лабораторийн ажилтан, нарийн бичиг, даргын жолооч, дэд захирал нарын ажлын ачаалал бага байгаа тул цаашид ажилтнуудын ажлын ачааллыг тэнцвэржүүлж ажиллах нь зүйтэй юм.

Аудитын хугацаанд ОНӨААТҮГ-ын ажиллагсдын боловсрол, мэргэжлийн судалгаа гаргаж, ажлын байрны тодорхойлолт түүнд заасан ажлын байрны шалгууртай харьцуулан шалгахад 2016 онд 21 ажилтан, 2017 онд 3 ажилтан ажлын байранд заасан шалгуурт нийцээгүй, мэргэжлийн бус иргэнийг ажлын байруудад ажиллуулсан зөрчлүүд илэрч байна. /Судалгааг хавсралтаар гаргасан/

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 /“мэргэжил” гэж тодорхой ажил, хөдөлмөр эрхлэхэд шаардагдах мэдлэг, чадвар, дадлын цогцыг/, 4.1.2 /“мэргэжлийн боловсрол” гэж тодорхой мэргэжлийн үйл ажиллагааг гүйцэтгэх хэрэгцээнд нийцүүлж зохион байгуулалттай сургалтаар эзэмшүүлсэн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хөдөлмөрийн болон харилцааны соёлын төлөвшлийг/ дахь заалтуудыг зөрчиж мэргэжлийн бус болон мэргэжил эзэмшээгүй иргэдийг ажиллуулж байгаа нь ажлын байрны тодорхойлолтод заасан тусгай шалгуур үзүүлэлтийг хангахгүй байна.

Цаашид дээрх ажлын байруудад ажиллах ажилтнуудыг сургалтанд хамруулах, мэргэжил эзэмшүүлэх талаар тодорхой ажил зохион байгуулах зөвлөмжийг хүргүүлж байна.

2016 онд 11 ажилтан шинээр ажилд орж, 8 ажилтан ажлаас чөлөөлөгдсөн бол 2017 онд 7 ажилтан шинээр ажилд орж, 4 ажилтан ажлаас чөлөөлөгдсөн байна.

2016 онд батлагдсан орон тооноос резерварын харуулууд ажиллаагүйгээс 47-48 орон тоотойгоор ажилласан бөгөөд 2016 оны 10 сард дэд захирал, 2017 онд бичиг хэргийн ажилтан, лабораторийн ажилтан, ахлах орлогын байцаагчийн нийт 6 орон тоо нэмж батлагдсан байна.

“Амь Ус” трейд ОНӨААТҮГ нь ажилтнуудыг сонгон шалгаруулж ажилд аваагүй нь үр нөлөөгүй, хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх зарчим алдагдах эрсдэл байгааг харуулж байна.

2.2. 2016 онд дэвшүүлсэн зорилго зорилтоо 88.4 хувьтайгаар биелүүлсэн бол, 2017 оны эхний улиралд 76.9 хувьтайгаар биелүүлсэн нь өмнөх оноос буурсан байна.

2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 56 ажил төлөвлөгдсөнөөс 49 ажил бүрэн биелж, 1 ажил 50 хувьтай, 6 ажил хэрэгжээгүй, ажлын гүйцэтгэл 88.4 хувьтай байна.

2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хүснэгтээр харуулбал:

Д/д	Зорилт	Хэрэгжүүлэх үйл ажиллагааны тоо	Хүрэх үр дүн
1	Байгууллагын дотоод ажлыг тогтмолжуулах	15	Ажлын хариуцлага сахилга өндөржиж, ажлын үр дүн тодорхой болно.
2	Үйлдвэрлэлийн хэвийн ажиллагааг хангах	18	Ажлын бүтээмж нэмэгдэнэ.
3	Санхүүгийн бүхий л үйл ажиллагаанд НББ-ийн хяналтыг сайжруулах	5	Үргүй зардал хэмнэгдэж, эдийн засгийн үр ашиг нэмэгдэнэ.
4	Авто техникийн бэлэн байдлыг хангах	10	Аюулгүй найдвартай ажиллагаа хангагдаж, цаг ашиглалт сайжирна.
5	Ажиллагсадын нийгмийн асуудлыг дээшлүүлэх, байгууллага, хамт олноо сурталчлах, байгаль орчноо хамгаалах	8	Ажиллагсадын урам зориг, идэвхи санаачлага нэмэгдэж, хөдөлмөрийн бүтээмж дээшлэнэ.

Хэрэгжээгүй ажлууд нь үйлдвэрлэлийн хэвийн ажиллагааг хангах зорилтын хүрээнд хэрэгжих:

- 500м3 резерварын ус алдалт, цууралт нэвчилтийг засварлах
- бохир усны 30ш худгийн ам өрлөг, кольцоо хоорондын заадасыг шавах
- септик (цэвэрлэх байгууламжийн төхөөрөмж) цэвэрлэх
- бохир усны насос станц №3-д бохир усны насос шинээр тавих ажлууд

Санхүүгийн бүхий л үйл ажиллагаанд НББ-ийн хяналтыг сайжруулах зорилтын хүрээнд хэрэгжих:

- өр, авлага барагдуулах ажлыг зохион байгуулж, найдваргүй авлагыг ТУЗ-ийн хурал болон шүүхээр шийдвэрлүүлэх ажил,

Авто техникийн бэлэн байдлыг хангах зорилтын хүрээнд:

- Кат-ын ком шанага солих, моторт ээлж хийх, гидрийн насос солих зэрэг ажлууд нь төсөв, хөрөнгө шийдэгдээгүй учираас хойшилж, септик цэвэрлэх ажил нь 2017 оны төлөвлөгөөнд дахин суугдсан байна.

2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хүснэгтээр харуулбал:

Д/д	Зорилт	Хэрэгжүүлэх үйл ажиллагааны тоо	Хүрэх үр дүн
1	Байгууллагын дотоод ажлыг тогтмолжуулах	16	Ажлын хариуцлага сахилга өндөржиж, ажлын үр дүн тодорхой болно.
2	Үйлдвэрлэлийн хэвийн ажиллагааг хангах	18	Аюулгүй найдвартай ажиллагаа хангагдаж, цаг ашиглалт сайжирна.
3	Санхүүгийн бүхий л үйл ажиллагаанд НББ-ийн хяналтыг сайжруулах	8	Үргүй зардал хэмнэгдэж, эдийн засгийн үр ашиг нэмэгдэнэ.
4	Авто техникийн бэлэн байдлыг хангах	10	Аюулгүй найдвартай ажиллагаа хангагдаж, цаг ашиглалт сайжирна.
5	Ажиллагсадын нийгмийн асуудлыг дээшлүүлэх, байгууллага, хамт олноо сурталчлах, байгаль орчноо хамгаалах	7	Ажиллагсадын урам зориг, идэвхи санаачлага нэмэгдэж, хөдөлмөрийн бүтээмж дээшлэнэ.

2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 59 ажил төлөвлөгдсөн, 1-р улиралд 26 ажил хийхээс 20 ажил бүрэн биелэж, 6 ажил хэрэгжээгүй, ажлын гүйцэтгэл 76.9 хувьтай байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад буурсан байна.

Аудитын явцад лабораторийн үйл ажиллагаатай танилцахад химийн бодисын ууршилтыг сорох төхөөрөмж суурилуулаагүй, “Ундны усны ерөнхий шаардлага” гэсэн стандартаар хангагдаагүй байгаагийн зэрэгцээ лабораторийн ажилтнууд нь усны шинжилгээ хийх туршлага багатай, үлдэгдэл хлорын шинжилгээг алдаатай хийж байгаа нь ажиглагдлаа.

Бүлэг 3. Хөрөнгийн зарим худалдан авалт нь хууль зөрчсөн, сэлбэг, шатахууны зарцуулалт арвилан хэмнэлт үр нөлөөгүй байна.

3.1. Гүйцэтгэх захирлуудын хийсэн 56.0 сая төгрөгийн худалдан авалт нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх тухай хуулиудыг зөрчсөн байна.

2016 онд 172.2 сая төгрөгийн хөрөнгийн худалдан авалтыг хийхдээ 46.0 сая төгрөгийн хөрөнгийг гүйцэтгэх захирал нар олж бэлтгэсэн, 23.3 сая төгрөгийн барилга байгууламжийг байгууллагын ажилчдын хүчээр барьж ашиглалтанд оруулсан, 38.0 сая төгрөгийн шатахууныг захирлын цохолтоор жолооч нар худалдан авсан, 64.9 сая төгрөгийн хөрөнгийг эд хариуцагч бэлтгэсэн байна.

2017 оны эхний улиралд 25.5 сая төгрөгийн бараа материал худалдан авснаас 10.0 сая төгрөгийн худалдан авалтыг гүйцэтгэх захирал хийн, 9.7 сая төгрөгийн шатахууныг захирлын цохолтоор жолооч нар худалдан авч, 5.8 сая төгрөгийн бараа материалын худалдан авалтыг эд хариуцагч хийжээ.

Хөрөнгийн худалдан авалтыг хийхдээ шаардлага гарсан тухай бүрд нь шууд худалдан авах аргыг ашиглаж байгаа боловч гүйцэтгэх захирлууд 10.0 сая хүртэлх төгрөгийн санхүүжилтийг урьдчилан авч хөрөнгө бэлтгэж байгаа нь худалдан авах ажиллагааны журмыг зөрчиж байна. Энэ зөрчлийг өмнөх аудитаар илрүүлэн албан шаардлага хүргүүлсэн боловч давтан үйлдсэн тул гүйцэтгэх захиралд холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцуулах саналыг үйлдвэрийн газрын ТУЗ-ийн даргад хүргүүллээ.

2016 онд 14.0 сая төгрөгийн тээврийн хэрэгслийг бэлтгэхдээ аймгийн ИТХ-аас шийдвэр гаргуулаагүй, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчсөн байна.

Гүйцэтгэх захирлууд шаардлагатай санхүүжилтийг урьдчилан аваад хөрөнгийг бэлтгэж байгаа нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-д “Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын дээд шүүхийн шүүгч, Улсын ерөнхий прокурор, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга, яамны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит компани, олон улсын байгууллагын дарга, захирлын албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд нээлттэй тендер шалгаруулалтаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд төрийн болон орон нутгийн хэрэгцээнд бараа, ажил, үйлчилгээ худалдан авагч, төрийн санхүүгийн нөөц бүрдүүлэгч, төрөөс баталгаа гаргасан зээл хүртэгч аж ахуйн нэгжийн хувь, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч байж болохгүй” гэж заасныг зөрчсөн байна.

3.2. Шаардлагатай хөрөнгө нөөцийн 32.5 хувийг урьдчилан төлөвлөлгүйгээр бэлтгэсэн байна.

2016 онд 125.8 сая төгрөгийн бараа материал, 46.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг олж бэлтгэхдээ 116.3 сая төгрөгийн хөрөнгийг байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан бол 55.9 сая төгрөгийн хөрөнгийг урьдчилан төлөвлөлгүйгээр бэлтгэсэн байна.

Тухайлбал:

-7.3 сая төгрөгийн өртгөөр Жаргалант багт шинэ усан сан шинээр барих ажил

-1.5 сая төгрөгийн өртгөөр Notebook худалдан авах

-13.6 сая төгрөгийн өртөгтэй насос, тоолуур

-33.5 сая төгрөгийн өртөгтэй бараа материал, сэлбэг хэрэгсэл

3.3. Шатахуун, сэлбэгийн зарцуулалтанд тавих дотоодын хяналт үр нөлөөгүй байна.

Хөрөнгийн зарцуулалтыг бараа материалын тайлангаас шалгахад шаардах, зарлагын баримтыг бүрэн бичсэн, зарлагын дүн нягтлан бодогчийн тооцоололтой тохирч байлаа. Харин шатахууны зарцуулалтанд тавих дотоодын хяналт хангалтгүй, спидометрийн заалтыг үндэслэдэггүй, сэлбэгийн зарцуулалтыг гаргахдаа техникийн комиссын актыг үйлддэггүй зэрэг зөрчил илэрлээ. Хөрөнгийн тооллогыг хэсэгчлэн хийхэд 0.1 сая төгрөгийн өртөгтэй мөнгөн аяга, 0.2 сая төгрөгийн өртөгтэй хүлэмж зэргийг зарлагадаагүй байна.

Бүлэг 4. Хөрөнгө оруулалтын ажлууд нь байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдан үр дүнтэй хэрэгжсэн байна.

4.1. Хөрөнгө оруулалтын ажлууд нь байгууллагын хэрэгцээ шаардлагад нийцсэн байна.

“Амь Ус” трейд ОНӨААТҮГ-т шалгалт хамрах хугацаанд хийгдсэн ажлуудыг хүснэгтээр харуулбал:

Д/д	Хийгдсэн ажлын нэр	Хаанаас санхүүжсэн	Мөнгөн дүн /сая.төг-рөгөөр/	Гүйцэтгэгч байгууллага
1	Улиастай сумын Богдын гол багийн цэвэр усны 1-р өргөлтийн станцаас Өлзийт багийн цэвэр усны 2-р өргөлтийн станц хоорондох 2.1 км цэвэр усны хос шугамын шинэчлэл	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	638.1	“Тэнгэрийн тэмдэг” ХХК
2	Улиастай сумын Жаргалант багийн нефтийн шинэ хэсэг Ус түгээх 19-р цэг барих	Сумын орон нутгийн хөгжлийн сан	7.3	Байгууллагын өөрсдийн хүчээр
3	Цэвэр усны шинжилгээний лабораторийн тоног төхөөрөмж авах	Сумын орон нутгийн хөгжлийн сан	5.0	“Чоно гол трейд” ХХК
4	Улиастай сумын Богдын гол багийн цэвэр усны 1-р өргөлтийн станцын гадна хамгаалалтын хашаа барих	-БОГ-ын байгаль хамгаалах сан -Байгууллагын өөрийн хөрөнгө	9.9 6.2	Байгууллагын өөрсдийн хүчээр
5	Улиастай сумын Чигэстэй, Өлзийт, Жаргалант, Товцог, Богдын гол багуудын Ус түгээх №1, 13, 16, 17, 18, 19-р цэгүүдийг эрүүл ахуйн хамгаалалтын бүстэй болгох	Байгууллагын өөрийн хөрөнгөөр	3.1	Байгууллагын өөрсдийн хүчээр

6	Улиастай сумын Жинст, Чигэстэй багийн резерварын ус түгээх 3 цэгийг хайс хамгаалалттай болгох	Дэлхийн Зөн Олон улсын байгууллага	6.0	Байгууллагын өөрсдийн хүчээр
7	Улиастай сумын Өлзийт багийн цэвэр усны 2-р өргөлтийн станцыг аюулгүй байдлыг хангах зорилгоор камержуулах	Дэлхийн Зөн Олон улсын байгууллага	0.95	Байгууллагын өөрсдийн хүчээр
8	Улиастай сумын Жинст багийн цэвэр усны насос станцад хамгаалалтын хашаа барих	Дэлхийн Зөн Олон улсын байгууллага	2.1	Байгууллагын өөрсдийн хүчээр
9	Улиастай сумын Жаргалант багийн нефтийн шинэ хэсэг Ус түгээх 19-р цэгт усан сангийн ёмкост суурилуулах	Дэлхийн Зөн Олон улсын байгууллага	3.5	Байгууллагын өөрсдийн хүчээр

Дээрхий ажлууд нь тус байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан, хэрэгцээ шаардлагад нийцсэн байна.

4.2. Хөрөнгө оруулалтын 1 ажилд ашиглагчийн хяналтыг тавьж ажилласан бөгөөд 8 ажлыг байгууллагын ажилчдын хүчээр хийж гүйцэтгэн ашиглалтанд оруулсан байна.

Улиастай сумын Богдын гол багийн цэвэр усны 1-р өргөлтийн станцаас Өлзийт багийн цэвэр усны 2-р өргөлтийн станц хоорондох 2.1 км цэвэр усны хос шугамын шинэчлэл хийх 638.1 сая төгрөгийн өртөгтэй ажлыг 2016.10.13-наас 2016.11.15-ны хооронд “Тэнгэрийн тэмдэг” ХХК гүйцэтгэж, улсын комиссын 2016.11.16-ны өдрийн 33/2016 дугаартай актаар хүлээн авч ашиглалтад оруулан, “Амь Ус” трейд ОНӨААТҮГ-аас ус сувгийн инженер Ц.Доржготов ашиглагчийн хяналтыг тавьж ажилласан байна.

Гүйцэтгэгч “Тэнгэрийн тэмдэг” ХХК-д улсын комисс 3 үүрэг даалгавар өгснийг биелүүлж ажилласан байна. “Амь-Ус трейд” ОНӨААТҮГ-т тус хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийн зураг, хүлээж авсан акт очоогүйгээс бүртгэлд тусгаагүй байна.

Бусад хөрөнгө оруулалтын ажлуудыг байгууллагын ажилчдын хүчээр хийж гүйцэтгэн ашиглалтад оруулсан байна.

4.3. Хөрөнгө оруулалтын ажлууд үр дүнтэй хэрэгжсэн байна.

2016 онд Улиастай сумын орон нутгийн хөгжлийн сан, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 10.1 сая төгрөг дутуу олгогдсон байна.

Улиастай сумын Богдын гол, Чигэстэй голын стакадтай тулгуур багануудад хагалбар хийх, шугамын трасыг өөрчлөх, үндсэн тулгууруудыг зөөх ажлын 19.4 сая төгрөгийн санхүүжилтийг орон нутгийн төсвөөс 2017 оны 1 дүгээр сард олгон ажил хийгдэж байна

Хийгдсэн ажлуудын санхүүжилтийг багцалж харуулбал:

Д/д	Эх үүсвэр	Мөнгөн дүн
1	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	638.1
2	Сумын орон нутгийн хөгжлийн сан	12.3
3	БОГ-ын байгаль хамгаалах сан	9.9
4	Дэлхийн Зөн Олон Улсын байгууллага	12.55
5	Байгууллагын өөрийн хөрөнгөөр	9.3
Дүн		682.15

682.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн дээрх 9 ажил нь 2016 онд ашиглалтанд орж, үр дүнгээ өгсөн байна.



Д.Гүнширийн усан сан



Эрүүл ахуйн хамгаалалтын хайс

Цэвэр усны хос шугамын шинэчлэл

Аудитаар 3.2 сая төгрөгийн төлбөр тогтоогдон, 25.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 115.0 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитаар илрүүлсэн нотлох зүйлсэд үндэслэн дараахь дүгнэлтийг гаргаж байна.

1. Зөөврийн усны орлогыг үндэслэлтэй төлөвлөсөн, өмнөх оны гүйцэтгэлээс айл өрхийн болон аж ахуйн нэгж байгууллагын борлуулалтын орлогыг дутуу төлөвлөсөн байна.
2. 2016 оны борлуулалтын орлого хангалттай хэмжээгээр төвлөрсөн бол 2017 оны борлуулалтын орлогын төвлөрсөн байдал өмнөх оноос буурсан байна.
3. “Амь-Ус Трейд” ОНӨААТҮГ-ын Төлөөлөн удирдах зөвлөл нь 2016 оны 1 дүгээр сард 51 орон тоотойгоор, 587.9 сая төгрөгийн зардалтай ажиллахаар төсвийг баталсан бөгөөд тайлант онд 581.7 сая төгрөгийн зардал гарган төсвийг 8.7 сая төгрөгөөр хэмнэсэн байна.
4. 2016 онд батлагдсан төсвөөс албан томилолт 1.3 сая төгрөгөөр, тэтгэмж 9.0 сая төгрөгөөр, бусад зардал 1.4 сая төгрөгөөр, нийгмийн арга хэмжээний зардал 5.1 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн бол найдваргүй авлагын зардал 2.5 сая төгрөгөөр, лабораторийн зардал 3.0 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.
5. 2017 оны 1-р улиралд батлагдсан төсвөөс цалингийн сан 1.9 сая төгрөгөөр, гэрэл цахилгааны зардал 1.0 сая төгрөгөөр, тэтгэмж 0.4 сая төгрөгөөр, бусад зардал 0.5 сая төгрөгөөр, элэгдлийн зардал 6.5 сая төгрөгөөр, шатахуун 0.5 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн байна.
6. 2016 онд 24.3 сая төгрөгийн ашигтай ажилласан бол 2017 оны эхний улиралд 11.7 сая төгрөгийн алдагдалтай ажиллан, цалин, шатахууны зардлуудыг үр ашиггүй, арвилан хэмнэлтгүй зарцуулж байна.
7. 2016 онд гүйцэтгэлээр 47-48 орон тоотойгоор ажиллаж байсан бол 2017 онд 2 слесарийн орон тоог цомхотгон, захиргаа аж ахуйн ажилтнуудын тоог 6 ажилтнаар нэмэгдүүлж, цалингийн сангийн төлөвлөлт өмнөх оноос 26.3 сая төгрөгөөр өссөнөөс шалтгаалан 2017 оны төсөв 617.0 сая төгрөгийн зардалтайгаар батлагдан өмнөх оны гүйцэтгэлээс 29.1 сая төгрөгөөр өсчээ.
8. Тайлант хугацаанд баяр ёслолын арга хэмжээ, шатахуун, сэлбэг, авто тээврийн хэрэгслийн худалдан авалт, удирдлагын цайны зардал, холбооны зардлыг 32.0 сая төгрөгөөр үр ашиггүй, арвилан хэмнэлтгүй зарцуулсан.
9. Айл өрх, албан байгууллагыг тоолууржуулаагүйгээс шалтгаалан жилд дунджаар 22 хувийн усны алдагдалтай ажиллаж, 152.5 сая төгрөгийн орлогыг алдаж байна.
10. 2016 оны эхэнд 51.9 сая төгрөгийн авлагатай байсныг тайлант онд 24.7 сая төгрөгөөр бууруулсан боловч 2017 оны 3 дугаар сарын 31-ний байдлаар

дахин авлага өсч 54.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй болсон байна.

11. Бүтэц орон тоогоо оновчтой зохион байгуулаагүй, орон тоо нэмэгдсэн, ажлын ачаалал харилцан адилгүй, мэргэжлийн бус ажилтнуудын тоо өндөр байгаад анхаарч ажиллах шаардлагатай байна.
12. 2016 онд дэвшүүлсэн зорилго, зорилтоо 88.4 хувьтайгаар биелүүлсэн бол, 2017 оны эхний улиралд 76.9 хувьтайгаар биелүүлсэн нь өмнөх оноос буурсан байна.
13. Гүйцэтгэх захирлуудын хийсэн 56.0 сая төгрөгийн худалдан авалт нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх тухай хуулиудыг зөрчсөн байна.
14. Шаардлагатай хөрөнгө нөөцийн 32.5 хувийг урьдчилан төлөвлөлгүйгээр бэлтгэсэн байна.
15. Шатахуун, сэлбэгийн зарцуулалтанд тавих дотоодын хяналт үр нөлөөгүй байна.
16. Хөрөнгө оруулалтын ажлууд нь байгууллагын хэрэгцээ шаардлагад нийцэж, үр дүнгээ өгчээ.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ: 2017 оноос орон тоо нь нэмэгдсэнээр удирдлагын зардал өсч, үйл ажиллагааны үр дүн буурч, алдагдалтай ажиллаж эхэлжээ.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Л.УЛАМБАЯР

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэнд үндэслэн дараахь зөвлөмжийг өгч байна.

ТУЗ-ийн дарга Ц.Балхярваа-д

1. “Амь-Ус трейд” ОНӨААТҮГ-ын орон тооны дээд хязгаарыг орон нутгийн Өмчийн газраар батлуулан, орон тоог нягтруулах шийдвэрийг гаргах
2. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй гүйцэтгэх захиралд холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцох
3. Шатахууны лимит тогтоон мөрдүүлэх, гүйцэтгэх захирлын ажлын гүйцэтгэл, үр дүнд тавих хяналтыг сайжруулан гэрээг хагас, бүтэн жилээр дүгнэх
4. Усны алдагдлыг бууруулах, орлогыг бүрэн төвлөрүүлэх талаар тодорхой ажил зохион байгуулах үүргийг гүйцэтгэх захиралд өгч хэрэгжилтэнд хяналт тавих
5. Орон нутгийн өмчийн газартай орон нутгийн өмч ашигласны түрээсийн гэрээг байгуулан, түрээсийн төлбөрийг орон нутагт төвлөрүүлж байх үүргийг гүйцэтгэх захиралд өгч хэрэгжүүлэх

Гүйцэтгэх захирал О.Бат-Өлзийд

1. Борлуулалтын орлогын төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөх, 2017 оны төлөвлөлтийн алдааг залруулан ТУЗ-аар батлуулах
2. ТУЗ-аас баталсан төсвийн хүрээнд зардал гаргах, шатахуун, холбоо, нийгмийн арга хэмжээний үрэлгэн хэрэглээг таслан зогсоож, холбооны зардлын лимитийг сарын 120.0 мянган төгрөгөөр бууруулан тогтоож, зарим шаардлагагүй ажилтныг холбооны зардлын жагсаалтаас хасах, холбооны лимит тогтоохдоо зах зээлийн хямд өртөгтэй үйлчилгээг нэвтрүүлэх
3. Ахлах орлогын байцаагчийн цалинг 80.0 мянган төгрөгөөр бууруулах, ажилтнуудын ажлын ачааллыг жигдрүүлэх
4. Усны алдагдлыг бууруулахын тулд 2-р өргөлтийн станц дээрх ерөнхий тоолуурыг засварлах, алдагдал гаргаж байгаа тайланд дурьдагдсан аж ахуйн нэгжүүдийг тоолууржуулж, усны алдагдлыг зогсоох арга хэмжээ авах, гэрээг шинэчлэх
5. Айл өрх, албан байгууллагыг үе шаттай тоолууржуулах ажлыг зохион байгуулах

6. Бараа материалын тайланд илэрсэн зөрчлийг арилган, дотоод хяналтыг сайжруулах, сэлбэг хэрэгслийг худалдан авахдаа техникийн комиссын акт бүрдүүлж хэвших
7. Ажлын байрны тодорхойлолтын шаардлагыг хангасан ажилтнуудаар хангах бодлогыг баримтлан, ажилтнуудыг сургах, дадлагажуулах талаар тодорхой ажил зохион байгуулах
8. “Тэнгэрийн тэмдэг” ХХК-ийн гүйцэтгэсэн цэвэр усны хос шугам шинэчлэх ажлын гүйцэтгэлийн зураг, улсын комиссын актыг холбогдох байгууллагаас авч, бүртгэлд тусгах
9. Шаардлагатай бараа материал, сэлбэг хэрэгслийг бэлтгэхдээ урьдчилан төлөвлөж, санхүүжилтийн хэмжээг ТУЗ-аар батлуулж хэвших, хөрөнгийг эд хариуцагчаар бэлтгүүлж байх
10. Лабораторийг шаардлагатай тоног төхөөрөмж, стандартаар хангах, лабораторийн ажилтнуудыг чадавхижуулах, үлдэгдэл хлорын шинжилгээнд тавих хяналтыг сайжруулах

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Л.УЛАМБАЯР

АГУУЛГА

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	1
Ерөнхий мэдээлэл	2
ОНӨААТҮГ нь орлого, зардлаа үндэслэлтэй төлөвлөж, үр ашигтай ажиллаж байна уу	2-8
ОНӨААТҮГ нь бүтэц, орон тоогоо оновчтой зохион байгуулан дэвшүүлсэн зорилго, зорилтоо хэр зэрэг биелүүлсэн бэ	9-11
Хөрөнгийн худалдан авалт, ашиглалт, зарцуулалт, арвилан хэмнэлт үр нөлөөтэй байна уу	12-13
Хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрөөр хийгдсэн ажил үр дүнтэй байна уу	14-16
Дүгнэлт	17-18
Зөвлөмж	19-20

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

- ОНӨААТҮГ - Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
- ИТХ -Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
- АДБОУС - Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
- ААНБ - Аж ахуйн нэгж байгууллага
- СӨХ -Сууц өмчлөгчдийн холбоо
- ОНХС - Орон нутгийн хөгжлийн сан
- НДШ -Нийгмийн даатгалын шимтгэл
- ТУЗ -Төлөөлөн Удирдах Зөвлөл
- УИХ - Улсын Их Хурал
- НББ -Нягтлан Бодох Бүртгэл
- ХХК -Хязгаарлагдмал хариуцлагатай компани
- БОГ Байгаль орчны газар